

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Аудитор Э.Сүнжидмаа

Утас: 80048599

Цахим хаяг: [Sunjidmaae@audit.gov.mn](mailto:Sunjidmaae@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар



АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.ЭНХТУЯА ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 89

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020321

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>143,588,218.70</b>	<b>142,099,846.48</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>13,127,422.08</b>	<b>13,492,233.81</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>13,127,422.08</b>	<b>13,492,233.81</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>13,127,422.08</b>	<b>13,492,233.81</b>
31211	Төрийн сангийн харилцах	13,127,422.08	13,492,233.81
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,802,100.00</b>	<b>0.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>4,802,100.00</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	4,802,100.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>125,658,696.62</b>	<b>128,607,612.67</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>125,658,696.62</b>	<b>128,607,612.67</b>
35410	Бичиг хэргийн материал	108,754,473.12	110,055,411.67
35420	Аж ахуйн материал	9,331,269.00	9,331,269.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,675,000.00	1,675,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,897,954.50	7,545,932.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>733,284,225.40</b>	<b>699,293,706.26</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>733,284,225.40</b>	<b>699,293,706.26</b>
39100	Газар	0.00	0.00
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>668,064,225.40</b>	<b>634,073,706.26</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	471,761,431.33	471,761,431.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,536,490.77	-40,637,874.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,000,000.00	120,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,594,860.08	-41,585,007.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	242,177,953.64	289,218,813.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-116,307,001.89	-169,025,346.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,194,758.99	49,194,758.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,631,565.82	-44,853,069.11
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>65,220,000.00</b>	<b>65,220,000.00</b>
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	65,220,000.00	65,220,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>876,872,444.10</b>	<b>841,393,552.74</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>876,872,444.10</b>	<b>841,393,552.74</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>876,872,444.10</b>	<b>841,393,552.74</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	583,511,152.93	583,511,152.93
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>186,240,994.50</b>	<b>150,762,103.14</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-21,075,121.17	186,240,994.50
51220	Тайлант үеийн үр дүн	207,316,115.67	-35,478,891.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,120,296.67	107,120,296.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>876,872,444.10</b>	<b>841,393,552.74</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,096,853,971.76</b>	<b>902,675,011.73</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>237,278,471.76</b>	<b>52,271,611.73</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>237,278,471.76</b>	<b>52,271,611.73</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>237,278,471.76</b>	<b>0.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	237,278,471.76	30,218,760.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	18,035,940.0
120009	Бусад орлого	0.00	7,016,911.73
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>859,575,500.00</b>	<b>847,403,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>844,355,500.00</b>	<b>843,609,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	844,355,500.00	843,609,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,220,000.00</b>	<b>3,794,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,220,000.00	3,794,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>889,537,856.09</b>	<b>938,153,903.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>889,537,856.09</b>	<b>938,153,903.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>839,855,394.33</b>	<b>898,828,221.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>579,316,449.56</b>	<b>592,434,500.00</b>
210101	Үндсэн цалин	346,002,549.56	338,447,081.26
210102	Нэмэгдэл	154,276,300.00	173,062,016.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,680,680.00	22,841,999.85
210104	Урамшуулал	43,356,920.00	58,083,402.85
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,051,706.24</b>	<b>76,883,639.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,378,006.24	53,989,107.74
210202	Тэтгэмжийн даатгал	6,418,400.00	6,020,856.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,134,700.00	4,816,684.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,283,700.00	1,148,533.16
210205	Эрүүл мэндийн даатгал	12,836,900.00	10,908,456.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,669,300.00</b>	<b>30,726,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,682,000.00	10,382,217.00
210302	Түлш, халаалт	27,862,000.00	17,321,040.00
210303	Цэвэр, бохир ус	2,125,300.00	3,023,643.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,590,705.50</b>	<b>24,545,513.95</b>
210401	Бичиг хэрэг	4,416,750.00	4,486,529.95
210402	Тээвэр, шатахуун	6,632,230.00	5,672,001.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,725,510.00	6,693,180.00
210404	Ном, хэвлэл	0.00	359,380.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,966,957.50	1,702,160.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,849,258.00	5,632,262.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,634,500.00</b>	<b>760,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210602	Тавилга	720,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	2,914,500.00	760,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,566,000.00</b>	<b>6,492,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,566,000.00	6,492,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>50,049,804.00</b>	<b>62,376,939.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,998,000.00	57,994,847.56
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,092.00	167,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,910,000.00	3,225,000.00
210807	Газрын төлбөр	80,712.00	96,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>68,976,929.03</b>	<b>104,608,729.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,960,000.00	16,745,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,188,450.00	6,832,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,828,479.03	81,031,379.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,682,461.76</b>	<b>39,325,681.44</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,818,525.00</b>	<b>35,830,444.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,787,525.00	25,384,344.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,031,000.00	10,446,100.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,863,936.76</b>	<b>3,495,237.44</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,763,936.76	3,495,237.44
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>207,316,115.67</b>	<b>-35,478,891.36</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>207,316,115.67</b>	<b>-35,478,891.36</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>872,445,350.44</b>	<b>854,420,311.73</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,869,850.44</b>	<b>7,016,911.73</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,869,850.44</b>	<b>7,016,911.73</b>
120009	Бусад орлого	12,869,850.44	7,016,911.73
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>859,575,500.00</b>	<b>847,403,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>844,355,500.00</b>	<b>843,609,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	844,355,500.00	843,609,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,220,000.00</b>	<b>3,794,000.00</b>

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,220,000.00	3,794,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>855,591,500.00</b>	<b>842,035,500.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>855,591,500.00</b>	<b>842,035,500.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>806,009,038.24</b>	<b>802,709,818.56</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>592,186,300.00</b>	<b>592,434,500.00</b>
210101	Үндсэн цалин	358,872,400.00	343,628,629.26
210102	Нэмэгдэл	154,276,300.00	173,062,016.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,680,680.00	22,841,999.85
210104	Урамшуулал	43,356,920.00	52,091,791.50
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,711,506.24</b>	<b>76,883,639.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,037,806.24	53,988,107.74
210202	Тэтгэмжийн даатгал	6,418,400.00	6,020,856.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,134,700.00	4,816,684.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,283,700.00	1,067,705.22
210205	Эрүүл мэндийн даатгал	12,836,900.00	10,990,284.78
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,669,300.00</b>	<b>30,726,900.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,682,000.00	10,382,217.00
210302	Түлш, халаалт	27,862,000.00	17,321,040.0
210303	Цэвэр, бохир ус	2,125,300.00	3,023,643.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,341,440.00</b>	<b>27,650,840.00</b>
210401	Бичиг хэрэг	3,579,900.00	7,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,632,230.00	5,672,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,772,310.00	6,482,500.00
210404	Ном, хэвлэл	447,600.00	386,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	695,400.00	1,113,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,214,000.00	6,436,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,958,500.00</b>	<b>760,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210602	Тавилга	720,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	7,238,500.00	760,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,579,400.00</b>	<b>6,492,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,579,400.00	6,492,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>50,318,592.00</b>	<b>62,441,393.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,998,000.00	59,204,847.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,592.00	167,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,911,000.00	20,800,000.0
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,244,000.00</b>	<b>5,320,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,960,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,284,000.00	5,320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,582,461.76</b>	<b>39,325,681.44</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,718,525.00</b>	<b>35,830,444.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,787,525.00	25,384,344.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,931,000.00	10,446,100.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,863,936.76</b>	<b>3,469,129.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,763,936.76	3,495,237.44
213304	Хөрөнгийн	0.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>16,853,850.44</b>	<b>12,384,811.73</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>7,200,000.00</b>	<b>12,020,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,200,000.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,200,000.00</b>	<b>0.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,200,000.00	12,020,000.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-7,200,000.00</b>	<b>-12,020,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>9,653,850.44</b>	<b>364,811.7</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,473,571.64	13,127,422.08
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,127,422.08	13,492,233.8
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0.00	0.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	-21,075,121.17	669,556,328.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	-21,075,121.17	669,556,328.43
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	207,316,115.67	207,316,115.67
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	186,240,994.50	876,872,444.10
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	186,240,994.50	876,872,444.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	186,240,994.50	876,872,444.10
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-35,478,891.36	-35,478,891.36
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	583,511,152.93	107,120,296.67	150,762,103.4	841,393,552.74

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>843,609,400.00</b>	<b>840,114,162.56</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>843,609,400.00</b>	<b>840,114,162.56</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>818,225,000.00</b>	<b>814,729,818.56</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>592,434,500.00</b>	<b>592,434,500.00</b>
210101	Үндсэн цалин	355,192,000.00	338,447,081.26
210102	Нэмэгдэл	102,786,000.00	173,062,016.39

210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,080,000.00	22,841,999.85
210104	Урамшуулал	76,376,500.00	58,083,402.50
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>79,954,600.00</b>	<b>76,883,639.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	56,257,200.00	53,988,107.74
210202	Тэтгэмжийн даатгал	5,924,300.00	6,020,856.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,739,500.00	4,816,684.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,184,900.00	1,067,705.22
210205	Эрүүл мэндийн даатгал	11,848,700.00	10,990,284.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,026,900.00</b>	<b>38,026,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,812,000.00	10,382,217.00
210302	Түлш, халаалт	30,793,000.00	24,621,040.00
210303	Цэвэр, бохир ус	3,421,900.00	3,023,643.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,989,000.00</b>	<b>27,650,840.00</b>
210401	Бичиг хэрэг	7,560,000.00	7,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,672,000.00	5,672,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,482,500.00	6,482,500.00
210404	Ном, хэвлэл	433,400.00	386,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,091,100.00	1,113,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,750,000.00	6,436,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>800,000.00</b>	<b>760,000.00</b>
210604	Урсгал засвар	800,000.00	760,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,492,000.00</b>	<b>6,492,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,492,000.00	6,492,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>67,208,000.00</b>	<b>67,161,939.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,230,900.00	59,204,847.56
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,100.00	167,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,820,000.00	6,800,000.00
210807	Газрын төлбөр	96,000.00	96,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,320,000.00</b>	<b>5,320,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,320,000.00	5,320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,384,400.00</b>	<b>25,384,400.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,384,400.00</b>	<b>25,384,400.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,384,400.00	25,384,400.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>843,609,400.00</b>	<b>840,114,162.56</b>

31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>843,609,400.00</b>	<b>840,114,162.56</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	843,609,400.00	840,114,162.56
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	13,127,422.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	13,492,233.8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>3,794,000.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,794,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,794,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,794,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,794,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>3,794,000.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,794,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,794,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

орсон байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулан ажиллах шаардлагатай байна. Иймд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 925.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 938.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15.0 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.2 хувиар буюу 33.9 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 13.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13.5 сая төгрөг байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 4.8 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан байна. Өглөгийн эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 128.1 сая төгрөг болж 2.6 сая төгрөгөөр өссөн нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 25.8 сая төгрөгийн бараа

материал бэлтгэж, 17.6 үнэ төлбөргүй хөрөнгө орлогоор тайлагнаж, үйл ажиллагаандаа 40.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өртөг 699.2 сая төгрөг болж буурсан нь тухайн жилийн элэгдлийн зардалтай холбоотой юм.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 841.0 сая төгрөг болж -35.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 150.4 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 784.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 59.0 сая төгрөгөөр өсгөж, 843.6 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээг улсын болон орон төсвөөс санхүүжүүлэхээр 843.6 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 843.6 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 3.8 сая төгрөг нийт 854.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 850.6 сая төгрөгийг зарцуулж, 3.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 836.2 сая төгрөг буюу 99.1 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 3.8 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 30 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 14.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна. Шийдвэрийн үлдэгдэл 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.1 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжүүлээгүйгээс аудитын явцад албан шаардлагын хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн жилийн аудитаар тээвэр шатахууны зардлыг давтан үзэх, зардлын эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж тайлагнасан эсэх, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 64.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 47.1 сая төгрөгийн зөрчлийг залруулан, 17.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 47.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

#### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **4.3 Албан шаардлага**

Зардлын эдийн засгийн ангилал зөрчин түлш халаалтын зардлаас халуун ус, бага даралтын уур үйлдвэрлэх халаалтын уурын тогоо 7.3 сая төгрөгөөр худалдан авсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн хэмнэлтийн гормыг зөрчиж 1.0 сая төгрөгийн контент хийлгэсэн нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.7-т "Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тээвэр шатахууны тооцоо бодоогүй анхан шатны баримтгүй 3.9 сая төгрөгийг зарцуулсан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар 1 заалт зөвлөмж өгөгдлөө.

Аудитаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд

**Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар:**

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 93 төгрөгийн 28 мэдээллээс, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Татварын хэлтэс	7	64.8	1	47.1			3	17.6	1	
5	Дүн	7	64.8	1	47.1			3	17.6	1	